

## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫТАЙЛАН

2021.06.18

Сайншанд сум

Тус хэлтэс нь 2021 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, иргэнд төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх, зорилгоор **“ЧАДВАРЛАГ БҮРТГЭГЧ-ЧАНАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭ”** зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.



### **Байгууллагын 2021 онд дэвшүүлсэн зорилт**

Дээрх зорилтын хүрээнд хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, бүртгэлийн үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэмжлэг, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ сумдыг юнител группын 4G, Хөвсгөл, Хатанбулаг сумдыг шилэн кабелиар улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд бүрэн холбуулж, сүлжээний хэвийн ажиллагааг хангаснаар иргэдийн цаг зав, зардлыг хэмнэж, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх нөхцөл бүрдсэн.



2. 1990-2000 онд төрсөн нийт 13555 иргэний төрсний бүртгэл /ИУБ-11/-ийг мэдээллийн санд тулган шалгаж, 741 бүртгэлийн алдаа илрүүлэн Улсын бүртгэлийн ерөнхий газарт албан бичгийг нотлох баримтын хамт хүргүүлж, зөрчлийг арилгасан.

3. Төрийн албан хэрэг хөтлөлтийг 2025 оноос үндэсний монгол бичгээр давхар хөтлөхтэй холбогдуулан үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас хэлтсийн 11 албан хаагчаас үндэсний бичгээр шалгалт авсан.

4. Төрийн үйлчилгээнд дэвшилтэт технологи ашиглан, түргэн шуурхай үйлчлүүлэх нөхцөлийг хангахүүднээс хэлтсийн [dornogovi.burtgel.gov.mn](http://dornogovi.burtgel.gov.mn) цахим хуудаст иргэний үнэмлэх, гадаад паспорт, эд хөрөнгийн эрхийн гэрчилгээ, хуулийн этгээдийн гэрчилгээг хэвлэгдсэн эсэхийг харах “**ОНЛАЙН ЛАВЛАГААНЫ СИСТЕМ**” программыг хэрэглээнд оруулсан. Уг программд иргэний үнэмлэх 572, гадаад паспорт 109, эд хөрөнгийн гэрчилгээ 4, хуулийн этгээдийн гэрчилгээ 11 хэвлэгдсэнийг шивэж оруулсан.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС  
ОНЛАЙН ЛАВЛАГААНЫ СИСТЕМ

ҮНДСЭН ВЭБСАЙТ НЭВТРЭХ

e-mongolia

ХЭВЛЭГДЭН ИРСЭН ТАЛААРХ ЛАВЛАГАА:

**ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ**

РЕГИСТРИЙН ДУГААР:  
A A 12345678

ХАЙХ

ДАХИН АВАХ

**ГАДААД ПАСПОРТ**

РЕГИСТРИЙН ДУГААР:  
A A 12345678

ХАЙХ

ДАХИН ЗАХИАЛАХ

**ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ**

РЕГИСТРИЙН ДУГААР:  
A A 12345678

ХАЙХ

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ**

РЕГИСТРИЙН ДУГААР:  
1234567

эсвэл оноосон нэрээр хайх  
Оноосон нэрээр хайх

ХАЙХ

[e-mongolia.mn](http://e-mongolia.mn) порталаас иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа, үйлчилгээг онлайнаар авах:

ИРГЭН & ГЭР БҮЛ | ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ | БИЗНЕС ЭРХЛЭЛТ & ӨРХИЙН АЖ АХУЙ

## Онлайн лавлагааны систем

### Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний улсын бүртгэлийн тасаг нь эхний хагас жилд нийт 1872 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

- Төрсний бүртгэл-622
- Үрчилсний бүртгэл-12
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-30
- Эцэг тогтоосны бүртгэл-35
- Гэрлэлтийн бүртгэл -153
- Гэрлэлт сэргээсний бүртгэл-0
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-29
- Нас баралтын бүртгэл-137
- Эх нотлох баримт, мэдээллийн сангийн мэдээллийн зөрчлийг арилгах засвар өөрчлөлтийн бүртгэл-741

- Нөхөн бичилтийн бүртгэл-92
- ИБЗ-1 бүртгэл-13
- Оршин суух хаяг тодорхойгүй төлөвт байгаа иргэнийг хаягийг суулгах-8

Эхний хагас жилд иргэний бүртгэлийн нийт 1854 лавлагаа, үүнээс хууль хяналтын байгууллагад 224 лавлагаа, албан хэрэгцээнд 210, иргэнд 1420 лавлагааг тус тус олгож, үйлчилгээ үзүүлсэн. Улсын төсөвт нийт 41170.5 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 7872.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

#### ***Иргэний шилжилт хөдөлгөөний чиглэлээр:***

“Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын дагуу энэ оныхагас жилийн байдлаар нийт 1643 иргэнд үйлчилгээ үзүүлсний дотор өөр аймаг, нийслэлээс шилжин ирсэн 364, сумаас шилжин ирсэн 348, баг хооронд шилжин ирсэн 931 иргэнийг бүртгэж, мэдээллийн санд оруулж баталгаажуулсан.

#### ***Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн чиглэлээр:***

Тайлант хугацаанд үндэсний гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтын нийт 966 /Үндэсний энгийн гадаад паспорт-153, БНХАУ нэг удаагийн хавсралт-0, БНХАУ олон удаагийн хавсралт-813/ бүртгэл хөтөлж, олгосон.

#### ***Иргэний үнэмлэх олгох ажлын хүрээнд:***

Тайлант хугацаанд нийт олгосон иргэний үнэмлэх 1835, үүнээс шинээр олгосон иргэний үнэмлэх 400, иргэний үнэмлэхээ гээгдүүлэн дахин олгосон иргэний үнэмлэх 570, иргэний үнэмлэхийн хугацаа дуусч 25, 45 насны сунгалт хийлгэсэн 865 иргэнд иргэний үнэмлэх олгосон.

Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдах 16 наснаас дээш насны иргэдийн судалгааг гарган, хурууны хээг авахаас өмнө мэдээллийн санд шалгаж, илэрсэн алдааг Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр албан бичгээр хүргүүлж, мэдээллийн санд тусгуулан ажилласан.

Сар бүрийн тоон мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

#### ***Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:***

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг хууль тогтоомжийн дагуу бүртгэж баталгаажуулах, бүртгэлийн чанар, хяналтыг дээшлүүлэх зорилготой ажиллалаа.

Эхний хагас жилийн байдлаар хэлтсийн хэмжээнд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхээ бүртгүүлэхээр иргэн, хуулийн этгээдээс 5552 мэдүүлгийг хүлээн авсан. Үүнээс:

- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл -116
- Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгүүлэх-67
- Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны өмчлөх эрх баталгаажуулалт -22

- Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн анхны бүртгэл -260
- Газар эзэмших ашиглах эрхийн Э.А дугаар олголт-1256
- Худалдах, худалдан авах гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл-381
- Бэлэглэх гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл-87
- Арилжах гэрээ-1
- Барьцааны гэрээ-2498
- Өв залгамжлах эрхийн бүртгэл-35
- Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх -3
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ -19
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 180
- Лавлагаа-621
- Бусад -6 тус тус бүртгэж, үйлчилгээ үзүүлсэн.

Иргэн, хуулийн этгээдээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцуулахаар ирүүлсэн 15 хүсэлт нотлох баримтыг үндэслэн хяналтын байцаагчийн дүгнэлтийг гаргуулан гэрчилгээг дахин бичиж олгосон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хүсэлтээр иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн бүртгэлийн талаарх 87 лавлагааг хүргүүлсэн. Нийт эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 5552 мэдүүлэг авч, бүртгэн, үйлчилгээний хураамжийн 155.581.577 төгрөгийг улсын төсөвт, 182.545.330 төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны татвар, тэмдэгийн хураамж 1.322.7879 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 3126 хувийн хэргийн эх нотлох баримтыг мэдээллийн санд цахимжуулсан баримттай тулган, нягтлан шалгаж илэрсэн зөрчлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 100 хувь арилгасан.

Сар бүрийн тоон мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

### **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”, холбогдох журам, бусад салбар хуулийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлсэн.

Тайлант хугацаанд дараах бүртгэлийг хийсэн. Үүнд:

- Шинээр байгуулагдсан нийт 99
- Хуулийн этгээдийн мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан нийт 108 өргөдлийг хүлээн авч тус тус бүртгэсэн.
- Хуулийн этгээдийн мэдээллийн сан, хувийн хэргээс нийт 24 лавлагаа, нийт 13 хуулбар олгосон.
- Тамга тэмдгийн хяналтын 110 дугаар олгож, 13 хуулийн этгээд тамга, тэмдгийг хураалгасан.
- Иргэний захиалсан 126 хуулийн этгээдийн нэрийг журмын дагуу баталгаажуулсан.

Нийт 493 бүртгэл хөтөлж, үйлчилгээ үзүүлэн, 6.642.000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн.

2021 оны 04 дүгээр сард УБЕГ-с Хуулийн этгээд ЭХЭУБ-д тусгай тэмдэглэлийг хийх, хүчингүй болгох бүртгэлийн талаар онлайн сургалтанд хамрагдсан.

2021 оны эхний хагас жилд хураалгасан хуулийн этгээдийн тамга, тэмдгийг журамд заасан хугацаанд акт үйлдэн устгаж, холбогдох баримтаар хадгаламжийн нэгж бүрдүүлэн, эх нотлох баримтын архивт хүлээлгэн өгсөн.

Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 68 хуулийн этгээдийн судалгаа мэдээллийг гаргаж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

Сар бүрийн тоон мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

### **Хяналт шалгалтын чиглэлээр:**

Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр боловсруулан, хэлтсийн даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Тайлант онд бүртгэлийн хяналтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

***Шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой хийсэн ажил:***  
Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн баталсан удирдамж, Хяналт, шалгалтын газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 8/1364, 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 8/2473 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу тус аймгийн 14 сумын улсын бүртгэгч нарын 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн баталсан удирдамж, Хяналт, шалгалтын газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 8/1364, 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 8/2473 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах талаар дотоод албан бичгээр зөвлөмж, чиглэл хүргүүлсэн.

2. Тус аймагт 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд нийт 997 шилжилт хөдөлгөөний бүртгэл хийснээс 1 бүртгэл хүчингүй болгосон. Аймгийн хэмжээнд нийслэлээс 109, бусад аймгаас 125, сум хооронд 219, баг хооронд 543 нийт 996 шилжилт хөдөлгөөний бүртгэлийн нотлох баримт, бүртгэлийн дэвтрийн хуулбар, ИУБ-22 маягтыг 7 хоног бүрийн 4, 5 дахь өдрүүдэд цахимаар хүлээн авч тухай бүрд нь шалгаж хянасан тухай тэмдэглэгээг хийжилэрсэн зөрчлийг арилгуулж, сум тус бүрээр болон аймгийн хэмжээний

шилжилт хөдөлгөөнийг нийслэлээс, бусад аймгаас, сумд хооронд, баг хоорондоор нь ялган мэдээг гаргаж нэгтгэн регистрийн дугаараар PDF файл үүсгэн хадгалсан.

3.2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд хийсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг шалгахад Замын-Үүд сумын улсын бүртгэгч С.Шүрэндулам Б.Золзаяа /ЕМ89110968/-ийн хамт шилжин ирсэн хүүхдийг бүртгээгүй, Даланжаргалан сумын улсын бүртгэгч Л.Нямхүү Ж.Сүхбаатар /СВ71011911/-ын хаягийг нотлох баримтаас зөрүүлж бүртгэсэн, Сайншанд сумын улсын бүртгэгч Г.Нандин-Эрдэнэ У.Эрдэнэжаргал /ЕГ69032108/-ын шилжилтийг өөр хүний нотлох баримттай хольж 2 дахин бүртгэж өөр хаягтай болгосон, Г.Биндэрмаа /Е388090405/-ийн хамт шилжин ирсэн 2 хүүхдийг бүртгээгүй, Э.Батчимэг /ЕА95032303/-ийг хаягийн нотлох баримтаас зөрүүлж бүртгэсэн, О.Нямдорж /ЕГ94070136/-ийн шилжилтийн бүртгэлийн төрлийг буруу сонгосон, Л.Цэцэгдарь /ЕБ76052041/-ийн шилжин ирсэн газрыг буруу сонгож бүртгэсэн нийт 7 зөрчил илрүүлж 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 1227, 1229, 1230, 1231, 1232 дугаар дүгнэлтээр зөрчлийг арилгасан. Мөн Замын-Үүд сумын улсын бүртгэгч С.Шүрэндуламын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдөр бүртгэсэн боловч баталгаажуулаагүй Э.Довчинсүрэн /ГМ91032103/-ийн шилжилтийн бүртгэлийн зөрчлийг илрүүлэн арилгуулсан.

4.Сумдын улсын бүртгэгчдээс бүртгэлийн тоон мэдээ, бүртгэлийн дэвтрийн сүүлийн бүртгэл, үлдсэн ИУБ-22 маягтын талаар урьдчилсан байдлаар 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр ажлын цаг дуусмагц цахимаар хүлээн авч нэгтгэж бүртгэлийн дэвтрүүдийг сүүлийн бүртгэлээр таслан, хаалт хийж тэмдэглэсэн эсэхийг шалгаж баримтжуулж авч шилжилт хөдөлгөөнийг хаахтай холбоотойгоор алдаа зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх үүднээс 23.10 цаг хүртэл улсын бүртгэгчдэд заавар, зөвлөмж өгч хамтран ажилласан.

#### ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛИЙН ТООН МЭДЭЭ

№	Сум	Нийслэлээс аймагт	Аймаг хооронд	Сум хороонд	Баг хороонд	Нийт
1	Айраг	5	8	7	4	24
2	Алтанширээ	-	-	5	5	10
3	Даланжаргалан	2	11	9	9	31
4	Дэлгэрэх	-	5	7	5	17
5	Иххэт	3	6	8	1	18
6	Мандах	-	1	5	3	9
7	Өргөн	3	4	11	8	26
8	Сайхандулаан	-	1	5	1	7
9	Улаанбадрах	-	-	9	7	16
10	Хатанбулаг	5	2	9	3	19
11	Хөвсгөл	-	1	4	-	5
12	Эрдэнэ	2	2	5	4	13
13	Замын-Үүд	40	37	21	189	287
14	Сайншанд	49	47	114	304	514
<b>НИЙТ</b>		<b>109</b>	<b>125</b>	<b>219</b>	<b>543</b>	<b>996</b>

## **Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой хяналтын чиглэлээр хийсэн ажил**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд хуулиар хүлээсэн чиг үргийн дагуу хэсэг оноолт, сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх, сонгуулийн хэсгийн хороо тус бүрд хүргэх, тоног төхөөрөмжийг хүлээн авах, хүлээлгэн өгөх, 57 хэсгийн хорооны 58 итгэмжлэгдсэн ажилтанд холбогдох цахим болон танхимын сургалтыг зохион байгуулах, заавар, зөвлөмж өгөх, цаг үеийн шинжтэй бусад холбогдох арга хэмжээнүүдийг шуурхай зохион байгуулж ажилласан. Мөн сонгуулийн өдөр итгэмжлэгдсэн ажилтнуудад заавар зөвлөмж өгч, иргэдийг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд болон [election.burtgel.gov.mn](http://election.burtgel.gov.mn) сайтад хандан шалгаж нийт 344 иргэнд сонгох эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлж ажилласан.

## **Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг газруудад хийсэн шалгалтын талаар**

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын дарга, улсын ерөнхий байцаагчийн баталсан 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн “Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь хэлтсээс иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын удирдамж”, Хяналт шалгалтын газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 8/1760 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэл, тус хэлтсийн 2021 оны хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөө, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтсийн хамтран баталсан удирдамжийн дагуу Дорноговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүр, мухлаг, ТҮЦ, гар дээр худалдагч, барьцаалан зээлдүүлэх газруудын үйл ажиллагаанд 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд аймгийн Цагдаагийн газраас томилогдсон бүрэлдэхүүний хамт Сайншанд суманд Хяналтын улсын байцаагч Өлзийчулуугийн Сонинбаяр, улсын бүртгэгч Э.Уранбилэг бичиг хэргийн ажилтан Г.Тэмүүлэннар, Замын-үүд суманд улсын бүртгэгч С.Шүрэндулам тус сумын цагдаагийн хэлтсээс томилогдсон бүрэлдэхүүний хамт, Даланжаргалан сумын улсын бүртгэгч Л.Нямхүү, Дэлгэрэх сумын улсын бүртгэгч Ж.Өлзийжаргал, Иххэт сумын улсын бүртгэгч Д.Мөнхцэцэг, Мандах сумын улсын бүртгэгч Н.Наран-Эрдэнэ, Өргөн сумын улсын бүртгэгч Б.Одбаяр, Улаанбадрах сумын улсын бүртгэгч С.Мөнхтуяа, Хөвсгөл сумын улсын бүртгэгч Т.Энхтуяа, Эрдэнэ сумын улсын бүртгэгч Ч.Энхжаргал нар сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хамтаар хүнсний дэлгүүр, мухлаг, ТҮЦ, гар дээр худалдагч, барьцаалан зээлдүүлэх газруудад иргэний бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалж байгаа эсэхэд хяналт шалгалтыг хийсэн.

Аймгийн төвийн Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй барьцаалан зээлдүүлэх газар, хүнсний дэлгүүрийн үйлчилгээ эрхэлдэг 150 хуулийн этгээдийн судалгааг гаргасан.

Ковид-19 цар тахлын улмаас шалгалт хийх хугацаанд өөрчлөлт оруулж хойшлогдсон бөгөөд мөн хөл хорио тогтоож зарим үйлчилгээний газруудын үйл

ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор зочид буудал, ресторан, зоогийн газар, цайны газар, авто машины засвар үйлчилгээ эрхэлдэг 69 газар, үйл ажиллагааны чиглэлийг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэхээр бүртгүүлсэн боловч уг үйл ажиллагааг эрхлэхгүй байгаа 18 хуулийн этгээд, 2021 он гарснаас хойш ажиллагаагүй 1 ломбард, 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 5 хүнсний дэлгүүр нийт 93 газар шалгалтанд хамрагдаагүй.

Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг 11 хуулийн этгээд, хүнсний дэлгүүрийн үйлчилгээ эрхэлдэг 46 дэлгүүр, мөн өмнө нь энэ төрлийн зөрчил гаргаж байсан сэлбэгийн худалдаа эрхэлдэг 1 дэлгүүр, гар дээрээс худалдаа эрхлэгч 1 иргэн нийт 59 газарт хяналт, шалгалт хийсэн.

Даланжаргалан суманд 20, Дэлгэрэх суманд 14, Иххэт суманд 18, Мандах суманд 6, Өргөн суманд 14, Улаанбадрах суманд 12, Хөвсгөл суманд 4, Эрдэнэ суманд 13, Замын-Үүд суманд 13, нийт 114 хуулийн этгээдэд хяналт шалгалтыг хийсэн.

Энэ удаагийн шалгалтаар аймгийн хэмжээнд нийт 10 сумын 173 нэгжид хяналт шалгалтыг хийж, 78 зөрчил илрүүлсэн байна.



1. Эрдэнэ сум



2. Мандах сум



3. Өргөн сум



4. Замын-Үүд сум



5. Улаанбадрах сум



6. Даланжаргалан сум





7. Дэлгэрэх сум



8. Иххэт сум



9. Сайншанд сум



10. Хөвсгөл сум

Сайншанд суманд хийсэн шалгалтаар 1 дэлгүүр, 2 барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг газраас 22 иргэний үнэмлэх, 3 гадаад паспорт, 50 төрсний гэрчилгээг барьцаалсан байсныг илрүүлж акт үйлдэн хураан авсан .Үүнд:

1. Зүүн ил ХХК нь 18 төрсний гэрчилгээг итгэмжлэл үйлдэн, барьцаалан авсан байсныг хураан авч Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгахад бүгд хүчинтэй.



2. Асманы булаг ХХК нь 3 иргэний үнэмлэх, 1 гадаад паспорт, 32 төрсний гэрчилгээг барьцаалан авсан байсныг хураан авч Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгахад 2 иргэний үнэмлэх, 1 гадаад паспорт, 6 төрсний гэрчилгээ хүчингүй , 1 иргэний үнэмлэх, 26 төрсний гэрчилгээ хүчинтэй;



3. Сэлбэгийн худалдаа эрхэлдэг иргэн Ч.Батсүх нь 2 гадаад паспорт, 19 иргэний үнэмлэх барьцаалан авсан байсныг хураан авч Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгахад 11 иргэний үнэмлэх, 1 гадаад паспорт хүчингүй, 8 иргэний үнэмлэх, 1 гадаад паспорт хүчинтэй байна.



Нийт шалгалтаар хураан авсан 75 бичиг баримтаас 13 иргэний үнэмлэх, 2 гадаад паспорт, 6 төрсний гэрчилгээ нийт 21 бичиг баримт хүчингүй болсон байна.


Замын-Үүд суманд хийсэн шалгалтаар 1 барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг газраас үл хөдлөх эд хөрөнгийн 3 гэрчилгээ барьцаалсан байсныг илрүүлж акт үйлдэн хураан авч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгахад 2 гэрчилгээ хүчингүй болсон давхар барьцаалсан зөрчил илэрсэн.

Аймгийн хэмжээнд энэ удаагийн шалгалтанд 1 иргэн, 172 хуулийн этгээд хамрагдсанаас 169 хуулийн этгээд иргэний үнэмлэх, гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан зөрчил үйлдээгүй байна.

Улсын бүртгэлийн хэлтэс нь чиг үүргийн хүрээнд 2009 он, 2017, 2020 онуудад барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг газруудад шалгалт хийж байсан. 2009 оны шалгалтаар Асманы булаг ХХК, 2017 оны шалгалтаар “Асманы булаг” ХХК, “Цагаан дөрвөлж” ХХК болон ЕЮ55112611 регистрийн дугаартай иргэн Ч.Батсүх /сэлбэгийн дэлгүүртэй/, ЕЭ54081873 регистрийн дугаартай иргэн

Л.Баянжаргал /гар дээрээс худалдагч/ нараас зөрчил илэрч байсан.2020 оны шалгалтаар “Асманы булаг” ХХК, “Цагаан дөрвөлж” ХХК, “Зүүн ил” ХХК, “Дэ гоулд буллион” ХХК-аас иргэний бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан 291 зөрчил илрүүлэн хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан. Мөн барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг газрууд, худалдаа үйлчилгээний төвүүдэд зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зөрчлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжуудаар боршуур, гарын авлага бэлтгэн тарааж, хуулийн этгээдийн мэдээллийн самбарт иргэний бичиг баримтыг барьцаалахыг хориглосон санамж байршуулж, аймгийн төвд нэгдсэн эмнэлэг явах зам дагуу иргэний бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалахыг хориглосон мэдээлэл бүхий 6х9 хэмжээтэй самбарыг хийж байршуулсан.

Өмнө хийгдсэн 2009 оны шалгалтаар 800 гаруй, 2017 оны шалгалтаар 540, 2020 оны шалгалтаар 291, энэ оны шалгалтаар 75 зөрчил илэрч иргэний бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан зөрчлийн тоо жил ирэх бүр буурч байна. Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг өмнө нь бичиг баримт барьцаалж байсан хуулийн этгээдүүд бичиг баримт барьцаалахаа больсон мөн “Асманы булаг” ХХК, “Зүүн ил” ХХК, иргэн Ч.Батсүх нар нь өмнө онуудад барьцаанд авсан байсан бичиг баримтаа иргэд ирж аваагүй шалтгаанаар одоог хүртэл хадгалж байгаа гэх тайлбартай 75 иргэний бичиг баримт хураагдсан нь энэ төрлийн зөрчил буурч байгааг харуулж байна.



Сайншанд суманд барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлж буй 11 газар, 46 хүнсний дэлгүүр, 1 сэлбэгийн дэлгүүр, 1 гар дээр худалдаа эрхлэгчийг шалгаж 75 зөрчил илрүүлж, 58 хуулийн этгээд 76 иргэнд холбогдох хууль эрх зүйн зөвлөгөө өгч, 160 ширхэг анхааруулга, санамжийг хийж үйлчилгээ эрхэлдэг газруудад тараасан.

Замын-Үүд суманд барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг 3 газар, 10 хүнсний дэлгүүрийг шалгаж 3 зөрчил илрүүлж 13 хуулийн этгээд, 28 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө өгч 41 гарын авлага боршуурыг тараасан.

Иргэний бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан 3 хуулийн этгээд, 1 иргэнд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхээр шалгах ажиллагаа явагдаж байна.

Барьцаалан зээлдүүлэх газруудад хийсэн шалгалтаар 2020 онд хамрагдсан газрын 32 хувь, 2021 онд 21 хувь нь зөрчил үйлдсэнийг илрүүллээ.

Энэ онд барьцаалан зээлдүүлэх газар 14, худалдаа үйлчилгээний 158, гар дээр худалдаа эрхлэгч 1, нийт 173 газар шалгалтанд хамрагдсан бөгөөд 4 газар иргэний бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан зөрчил гаргасан нь нийт шалгалтанд хамрагдсан газруудын 2 хувь нь Улсын бүртгэлтэй холбоотой хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргасан байна.

Иймд хүнсний дэлгүүр, мухлаг, ТҮЦ, гар дээр худалдагч, зочид буудал, ресторан, зоогийн газар, цайны газар, авто машины засвар үйлчилгээ эрхэлдэг газар, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газруудад иргэний бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалж буй эсэхэд тавих хяналтыг чангатгах, иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн хууль, тогтоомжтой холбоотой зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр боршуур, гарын авлага бэлтгэн хүргүүлэх, хүн олноор үйлчлүүлдэг худалдаа үйлчилгээний төв, албан газруудад мэдээллийн самбар аялуулах, цахим орчинд хууль тогтоомжийг сурталчилан иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

### ШАЛГАЛТААР ХУРААН АВСАН БАРИМТ БИЧГИЙН ТООН МЭДЭЭ

Д/д	Сум	Шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд	Баримт бичиг барьцаалсан иргэн, хуулийн этгээд	Хураан авсан баримт бичгийн төрөл, тоо				
				Иргэний үнэмлэх	Үндэсний энгийн гадаад паспорт	Төрсний улсын бүртгэлийн гэрчилгээ	Гэрлэсний улсын бүртгэлийн гэрчилгээ	Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх улсын бүртгэлийн гэрчилгээ
1	Айраг	-	-	-	-	-	-	-
2	Алтанширээ	-	-	-	-	-	-	-
3	Даланжаргалан	20	0	-	-	-	-	-
4	Дэлгэрэх	14	0	-	-	-	-	-
5	Замынүүд	13	1	-	-	-	-	3
6	Иххэт	18	0	-	-	-	-	-
7	Мандах	6	0	-	-	-	-	-
8	Өргөн	14	0	-	-	-	-	-
9	Сайншанд	59	3	22	3	50	-	-
10	Сайхандулаан	-	-	-	-	-	-	-
11	Улаанбадрах	12	0	-	-	-	-	-
12	Хатанбулаг	-	-	-	-	-	-	-
13	Хөвсгөл	4	0	-	-	-	-	-
14	Эрдэнэ	13	0	-	-	-	-	-
<b>Нийт хамрагдсан иргэн хуулийн этгээд, зөрчил</b>		<b>173</b>	<b>4</b>	<b>22</b>	<b>3</b>	<b>50</b>		<b>3</b>
Нийт 1 иргэн, 2 хуулийн этгээдээс				78 ширхэг баримт бичиг хураасан.				

### **Бүртгэлийн хяналтын чиглэлээр:**

Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав.

Энэ оны бүртгэлийн хяналтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт шалгалтыг 3 удаа хийсэн.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2697, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 68, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 50, архивын чиглэлээр 1333 бүртгэл шалгаж, нийт 454 зөрчил илрүүлэн арилгуулах арга хэмжээ авч ажиллав.

Бүртгэлийн зөрчлийг арилгахаар иргэд болон улсын бүртгэгчдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, тайлбарын дагуу иргэний улсын бүртгэлтэй холбоотой 55, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 47 нийт 103 дүгнэлтийг боловсруулан зөрчлийг арилгасан. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэсэн.

#### ДҮГНЭЛТИЙН БҮРТГЭЛИЙГ БҮРТГЭЛИЙН ТӨРЛӨӨР НЬ АНГИЛСАН СУДАЛГАА

/2021.01.01-2021.05.25-ны өдрийн байдлаар/

№	Бүртгэлийн төрөл	Гаргасан дүгнэлтийн тоо	Шийдвэрлэсэн зөрчлийн тоо	Хүчингүй болгосон бүртгэлийн тоо	Нийт гаргасан дүгнэлтэд эзлэх хувь
1	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр	55	75	591	53%
2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр	47	59		46%
3	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр	1	7		1%
	Нийт	103	135	591	100 %

Бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалт болон сар бүрийн мэдээ, судалгааг нэгтгэн гаргаж илэрч буй алдаа, зөрчилд дүгнэлт хийж, зөрчлийг давтан гаргуулахгүй байх үүднээс улсын бүртгэгчдэд дотоод албан бичгээр 4 чиглэл, зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Мөн дүгнэлтээр засагдаж буй улсын бүртгэгчдийн гаргасан зөрчлийн судалгааг бүртгэгч тус бүрээр гаргаж санамж анхааруулга өгч байна.



**Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:**


Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 55 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 1 хуулийн этгээд, 54 хүнд 1605.0 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан байна.

Аймгийн хэмжээнд шийдвэрлэгдэж буй зөрчлийг сумдаар нь болон төрлөөр нь ангилан сар, улирлаар судалгаа гаргаж, хамгийн их үйлдэгдэж байгаа зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар дараагийн хийх ажлаа төлөвлөдөг.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болохтой холбогдуулан иргэдийн иргэний үнэмлэхийн зөрчлийг арилгуулахаар өмнөх онд болон тайлант онд 25, 45 насны сунгалтын бүртгэл хийлгэх иргэдийн судалгааг гаргуулан, багуудын ажлын албатай хамтран иргэдэд мэдээлэл хүргүүлэн ажиллав.

“Зөрчлөөс урьдчилан сэргийлье” нэртэй мэдээллийн самбарт иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр Зөрчлийн тухай хуульд тусгагдсан заалтууд, тухайн сар, улирлын зөрчлийн тоон мэдээг тогтмол шинэчлэн байрлуулж байна.

Иргэдэд хугацаатай бүртгэлүүдээр санамж анхааруулга, гарын авлага боршуурыг хэвлэж 160 ширхэгийг тараасан.



Аймгийн Прокурорын газарт Зөрчлийн хэргийн мэдээг сар бүр 2 удаа гаргаж хүргүүлсэн.

#### **Архивын ажлын хүрээнд:**

Иргэний гэр бүлийн бүртгэлийн мэдээний маягт болох ИУБ-11 маягт 622 ширхэг, ИУБ-12 маягт 12 ширхэг, ИУБ-13 маягт 30 ширхэг, ИУБ-14 маягт 35 ширхэг, ИУБ-15 маягт 153 ширхэг, ИУБ-16 маягт 29 ширхэг, ИУБ-18 маягт 137 ширхэг, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан болон 25, 45 насны сунгалт хийлгэсэн 877 ширхэг ИУБ-31 маягт, нийт 1895 ИУБ маягтыг архивын санд байрлуулан, баяжилтыг тухай бүр хийсэн.

Тайлант хугацаанд өөр аймаг, хотоос шилжин ирсэн 364 иргэний хувийн хэргийг архивын санд байрлуулж, аймаг болон нийслэлрүү 119 хувийн хэрэг явуулсан.

Тус архивт өнөөдрийн байдлаар насанд хүрсэн 49938 иргэний, насанд хүрээгүй хүүхдийн хувийн хэрэг 25103, нас барсан 14992 иргэний хувийн хэрэг, иргэний үнэмлэх аваагүй 119 иргэний, харьяатаас гарсан 96 иргэний хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн 1902 хувийн хэрэг хадгалагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд хуулийн этгээдийн 99 бүртгэлийн баримтыг архив руу шилжүүлснийг ERS програмд архивлах төлөвт 100% шилжүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт үл хөдлөх эд хөрөнгийн 14206, газрын 8007 нийт 22213 хувийн хэрэг хадгалагдаж байгаа бөгөөд энэ онд үл хөдлөх эд хөрөнгийн 205, газар өмчлөх эрхийн 260 хувийн хэрэг шинээр үүссэнийг архивт хүлээн авсан.

Сар бүрийн архивын тоон мэдээг гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн.

**Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд:**

Улсын бүртгэлийн хэлтсээс 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг амжилттай зохион байгуулж, Улсын бүртгэлийн байгууллагын хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд хуулиар хүлээсэн чиг үргийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, сонгуулийн хэсгийн хороо тус бүрд хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн аймгийн хэмжээнд нийт Монгол Улсын Ерөнхийлөгчийн 57 хэсгийн хорооны 58 итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулж, холбогдох цахим болон танхимын сургалтыг зохион байгуулан, шуурхай удирдлагын баг сонгуулийн өдөр арга зүйгээр хангаж, амжилттай ажиллалаа.




***МУЕрөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн сонгогчийн нэрийн жагсаалт хүлээлцсэн нь***

СЕХ-ны даргын тушаалаар тус хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн дарга Б.Баттуяа 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 12-ны өдрийг дуусах хүртэлх хугацаанд аймгийн Сонгуулийн хорооны гишүүнээр ажилласан.





Иргэдийг [election.burtgel.gov.mn](http://election.burtgel.gov.mn) сайтад хандан сонгогчийг хувийн мэдээлэлтэйгээ танилцах боломжоор хангаж, нийт 1438 иргэн мэдээлэлтэй танилцсан. Мөн сонгогчийг хувийн мэдээлэлтэйгээ хэрхэн танилцах тухай гарын авлага, зөвлөмжийг худалдаа үйлчилгээний томоохон төвүүдэд байрлуулсан.



***election.burtgel.gov.mn* сайтаас иргэд сонгогчийн хувийн мэдээлэлтэйгээ танилцаж байгаа нь**





### **Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудын онлайн болон техникийн сургалтууд**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нийт 30 төрлийн үйл ажиллагааг гүйцэтгэхээр төлөвлөн, 100 хувь чанартай зохион байгуулав.

**Бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эрх зүйн боловсролыг иргэн бүрд хүргэх ажлын хүрээнд:**


Иргэдэд улсын бүртгэлийн хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, бүртгэлийн үйлчилгээ, мэдээллийг олон төрлийн байдлаар нийтэд шуурхай, чанартай хүргэхэд анхаарч, дараах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

- “МОНЦАМЭ” сонинд 1 удаа, FM-д 1 удаа мэдээлэл, УБЕГ-аас гаргасан 5 видео сурталчилгааг иргэд олноор цуглардаг аймгийн Гэр бүлийн талбайн LED дэлгэцээр 2 удаа 3 хоногийн турш цацаж, улсын бүртгэлийн багц хууль, үйлчилгээний талаар сурталчилсан.
- Хэлтсийн үйлчилгээний танхимын гадна байрлах мэдээллийн самбарт чиглэл тусбүрээр холбогдох мэдээлэл, сарын тоон мэдээг сар бүр шинэчлэн байрлуулсан.
- Мөн 7 хоног бүрийн цаг үеийн ажлын мэдээллийг АЗДТГ-т хүргүүлж хэвшсэн нь орон нутгийн удирдлагад байгууллагын үйл ажиллагааг таниулах, мэдээллийг цаг алдалгүй хүргэсэн.
- Хэлтсээс зохион байгуулсан болон хэрэгжүүлж байгаа цаг үеийн онцлог ажлын мэдээллийг [dornogovi.burtgel.gov.mn](http://dornogovi.burtgel.gov.mn) цахим сайт болон “Дорноговь аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс” нүүр номын хуудаст тогтмол байрлуулсан. Пэйж хуудаст нийт 51 мэдээллийг давхардсан тоогоор 130 удаагийн давтамжтай оруулсан нь нийт 21350 хүнд хүрсэн. Цахим сайтад 9235 иргэн хандаж мэдээлэл авсан.
- “Нүүдэлчин самбар”-ыг 10 байгууллагад тус бүр 2 хоногийн хугацаатай аялуулсан.



**Нүүдэлчин самбар**

- Хэлтсийн үйлчилгээний танхим дахь зурагтаар e-Mongolia, УБЕГ-аас гаргасан болон Авлигатай тэмцэх газраас гаргасан шторкуудыг тогтмол гаргаж байна.



**Хэлтсийн үйлчилгээний танхим дахь зурагтаар шторк мэдээлэл иргэдэд түгээх нь**

- Иргэдийн захиалсан 1835 иргэний үнэмлэх, 153 үндэсний энгийн гадаад Паспорт хэвлэгдэн ирснийг нийт 1988 иргэнд мессэжээр илгээж, цаг алдалгүй шуурхай үйлчилсэн.
- Иргэний улсын бүртгэгч Б.Баянбат Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд хоригдож буй 3 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн 1 иргэн, Мандах сумын улсын бүртгэгч Н.Наран-Эрдэнэ хөгжлийн бэрхшээлтэй 1

иргэний хүсэлтээр тус тус очиж биеийн давхцахгүй өгөгдлийг бүртгэж, иргэний үнэмлэхийн хугацааны сунгалтыг хийсэн.



***Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2 иргэний биеийн давхцахгүй өгөгдлийг бүртгэсэн нь***

- Гэр бүлийн хөгжил, боловсрол, тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчныг бий болгох, зорилгоор ёслол хүндэтгэлийн буланд шинээр гэр бүл болж буй 3 хосын гэрлэлтийг баталж, гэрлэсний гэрчилгээг, 5 иргэний төрсний гэрчилгээг эцэг эхэд нь ёслол хүндэтгэлтэйгээр гардуулж өгөх үйл ажиллагааг зохион байгуулж, дурсгалын зураг авсан.



Мөн энэ жилээс эхлэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран шинээр гэр бүл бологсдод соён гэгээрүүлэх сургалтын арга хэмжээг зохион байгуулж тангаргын бичигт гарын үсэг зуруулан гэрлэлтийг баталж байгаа ба 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдөр “Олон Улсын Гэр бүлийн өдөр”-өөр шинээр гэр

бүл болсон 2 гэр бүлийн гэрлэлтийн гэрчилгээг аймгийн “Хуримын ордон”-д гардуулж, ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулсан.

- Тайлант хугацаанд хэлтсийн лавлах утасны дугаарт хандсан 647 дуудлага хүлээн авч, зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн.

### **Covid-19 цар тахлаас сэргийлэх ажлын хүрээнд:**

1. Улсын бүртгэгч Б.Баянбат нь Сайншанд сумын 3 замын постны хяналтын цэгт 2 удаа 24 цагийн хугацаатай эргүүлд гарч үүрэг гүйцэтгэн ажиллаа.



### ***Сайншанд сумын 3 замын постны хяналтын цэгт Улсын бүртгэгч Б.Баянбат ажилласан нь***

2. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 2021 оны 04-р сарын 01-ны өдөр тус аймагт өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжинсэнтэй холбоотой хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу нийт албан хаагчид 2021 оны 04-р сарын 01-ний өдрөөс 04-р сарын 04-ний өдрүүдэд өглөөний 06 цагаас шөнийн 00 цаг хүртэл 12 цагийн хугацаатайгаар нийт 48 цаг Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр болох Дэнжийн дэлгүүрээс Зүүнбаянгийн пост хүртлэх нутаг дэвсгэрт Старекс /70-18 ДГО/ авто машинтайгаар эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн.

2021 оны 04 дүгээр сарын 01-ний 06:00 цагаас 00:00 цагийн хооронд Хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр, Ахлах нягтлан бодогч У.Буянбат, Улсын

бүртгэгч Д.Сарантуяа, Бичиг хэргийн ажилтан Г.Тэмүүлэн, Жолооч Б.Шинэбаяр нарын бүрэлдэхүүнтэй эргүүлийн үүрэг гүйцэтгэж, тус нутаг дэвсгэрт 32-93, 96-99, 15-18 ДГО, 18-37 ДГС, 74-78 УБӨ, 41-61 ДГО дугаартай автомашинууд зорчих хөдөлгөөнд оролцох гэж байсныг Аймгийн онцгой комиссоос гаргасан шийдвэрийг танилцуулж, шаардлага тавин ажилласан. Мөн 7 иргэн явганаар зорчиж байсныг гэрт нь буцаах арга хэмжээ авсан.

2021.04.02-ны өдөр Улсын ахлах бүртгэгч Т.Оюунчимэг, улсын бүртгэгч Г.Батсайхан, Сайншанд сумын улсын бүртгэгч Г.Нандин-Эрдэнэ, жолооч Б.Шинэбаяр нарын бүрэлдэхүүнтэй 06:00-00:00 цаг хүртгэл эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн.

Үүрэг гүйцэтгэх явцад 2 мотоциклтэй 3 иргэний зорчих хөдөлгөөнийг зогсоосон. Мөн 37-98 ДГО, 94-84 ДГС гэсэн автомашинуудыг зорчих хөдөлгөөнд оролцох гэж байсныг болиулж буцаасан.



2021.04.03-ны өдөр Улсын ахлах бүртгэгч Б.Баттуяа, улсын бүртгэгч Ж.Болортуяа, улсын бүртгэгч С.Эрдэнэхишиг, жолооч Б.Шинэбаяр нарын бүрэлдэхүүнтэй эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн. Тус хугацаанд гарсан зөрчилгүй.

2021.04.04-ны өдөр улсын бүртгэгч Э.Уранбилэг, мэдээлэл технологийн ажилтан П.Азжаргал, архивч Э.Эрдэнэмандах, жолооч Б.Шинэбаяр нарын бүрэлдэхүүнтэй эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн. 12:55 минутын орчимд Дэнжийн 2 давхар орон сууцны гадаа 2 иргэн явганаар зорчих гэж байсныг заавар зөмлөмж өгч гэрт нь буцаасан.



Эргүүлийн үүрэг гүйцэтгэх 4 хоногийн хугацаанд тус нутаг дэвсгэрт ноцтой зөрчил илрээгүй бөгөөд дээр дурдсан иргэдэд холбогдох заавар зөвлөмжийг өгч КОВИД-19 цар тахалын улмаас тогтоосон хөл хорионы үеийн дэглэмийг мөрдүүлж ажиллав.

3. Мөн тус хэлтсийн жолооч Б.Шинэбаяр нь тогтоосон хуваарийн дагуу 2 удаа 48 цагийн хугацаатай Мандах, Сайхандулаан сумын орох гарах постод хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажилласан.



4. Замын-Үүд сумын улсын бүртгэгч Х.Хүрэлцэцэг сумын онцгой комиссын шуурхай штабын байранд 2 удаа, 14 хоног ковидын шинжилгээ авч буй байранд жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн.

Бусад хөдөөгийн 12 сумын улсын бүртгэгч нар тус тусын харъяа сумандаа шуурхай штабын жижүүрийн үүрэг гүйцэтгэхээс гадна мөн сумаас орох, гарах постод хөдөлгөөнт эргүүлийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.



5. Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдлын Зэрэгт шилжсэнтэй холбогдуулан, хэлтсийн дарга ОБГ-ын алба хаагчийн хамт аймгийн Шуурхай штабын байранд энэ онд 8 удаа хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэж, холбогдох мэдээ тайланг Улсын онцгой комисст хугацаанд нь хүргүүлсэн.



**Аймгийн Шуурхай штабт хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн.**

6. Аймгийн онцгой комиссоос баталсан хуваарийн дагуу Улсын бүртгэгч Э.Уранбилэг, жолооч Б.Шинэбаяр нар 3 удаагийн давтамжтайгаар 30 байгууллагад QR кодыг байршуулсан талаар болон хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.




7. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд зориулсан сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимаас цахим хэлбэрээр зохион байгуулж, Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуульд ажиллах 58 итгэмжлэгдсэн ажилтныг хамруулсан ба төвийн 10 итгэмжлэгдсэн ажилтнуудыг 1-2 метр зайтай суулгаж, амны хаалт зүүж, биеийн халууныг 2 цаг тутамд хэмжиж, цар тахлын үеийн дэглэмийг мөрдөж ажилласан.





### **Итгэмжлэгдсэн ажилтанд зориулсан эрх зүйн онлайн сургалт**

8. Байгууллагын гадна хаалганд “Амны хаалт зүүж үйлчлүүлнэ үү”, “Амны хаалтгүй иргэнд үйлчлэхгүй” гэсэн анхааруулга бүхий санамж, иргэний үйлчлүүлэх хоорондын зай барих хөлийн мөр зэргийг нааж байршуулсан ба амны хаалтгүй иргэн нэвтэрсэн тухай бүрд амны хаалт зүүхийг анхааруулж, гараа ариутгаж үйлчлүүлэх шаардлага тавьж ажилласан.



### **Ковид-19 цар тахлын үеэр авсан арга хэмжээ**



9. Ковид-19 цар тахалтай холбоотой Хэлтсийн албан хаагч нар батлагдсан хуваарын дагуу ирж үйлчлүүлж буй иргэдийн халууныг хэмжиж, ариутган бүртгэж халдвар хамгааллын дэглэм сахин ажилллаж байна.



10. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн ариутгалын бодис, амны хаалт, бээлий, нүүрний хамгаалалт, агаар шүүгч, гар ариутгагч, өрөө тасалгаа ариутгагч, нэг удаагийн малгай, нэг удаагийн хамгаалалтын хувцас зэргийг тус хэлтсийн албан хаагчдад тарааж, өрөө тасалгааг тогтмол ариутгаж иргэдэд үйлчилгээ үзүүлж ажиллаа.



**УБЕГ-аас олгосон шаардлагатай үед хэрэглэх ариутгал хамгаалах хэрэгслийн нөөц**



11. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу албан хаагч тухайн өдрийн бүртгэл мэдээ мэдээлийг нэгтгэн цахимаар илгээн ажиллаж байна.

### **Төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдал:**

Хуульд заасны дагуу байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн тайлан, 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2021 оны санхүүгийн тайлан, 2021 оны төсөв, төсвийн байгууллагын санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, мэдээллийг тухай бүр хугацаанд нь шинэчлэн, шилэн дансанд нийт 50 мэдээллийг байрлуулсан.

### **Санхүү, аж ахуй үйлчилгээний ажлын хүрээнд:**

Улсын бүртгэлийн хэлтэс нь эхний хагас жилийн байдлаар 128690.0 мянган төгрөгийн үйлчилгээний орлогыг олж 128690.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн орон нутгийн төсөвт торгууль, шийтгэлийн орлогоор 1605.0 мянган төгрөг, тэмдэгтийн хураамжаар 16478.0 мянган төгрөг, үл хөдлөх борлуулсны орлогоор 174810.3 мянган төгрөг нийт 192893.3 мянган төгрөгийн орлого оруулсан. Тус хэлтсийн зардлын төсөв 2021 онд 402947.2 мянган төгрөгөөр батлагдсан. 5 дугаар сарын байдлаар 183909.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 180985.2 мянган төгрөгийг зохих зардлуудад төсвийн хуваарийн дагуу зарцуулан ажилласан байна. Улсын бүртгэлийн хэлтсийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн программ ашиглаж олон улсын стандартад нийцүүлэн хөтөлж, байгууллагын мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хүрээнд байнгын хяналт тавьж, төсвийн гүйцэтгэлийн болон орлогын сар бүрийн мэдээг 5 удаа хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж СТСХэлтэст болон УБЕГ-т хүргүүлсэн. 2021 оны 1-р улирлын санхүүгийн тайланг гаргаж, УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. 2020 оны санхүүгийн тайланд аудитын зөрчилгүй дүгнэлт авсан.

УБЕГ-аас болон бусад байгууллагаас 9722634 төгрөгийн үнэт цаас, маягт болон 2348310 төгрөгийн бусад бараа материал, жижиг эд хогшлыг бэлтгэж хангалтыг тасалдуулалгүй, мөн бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан.

Байгууллагын үнэт цаасны тооллого, хүчингүй болгосон үнэт цаас, үнэт цаасны зарцуулалт зэргээр 5 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.

### **Сургалтын чиглэлээр:**


Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадавхийг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд тайлант хугацаанд алба хаагчид дараах сургалтуудад хамрагдсан.

***УБЕГ-аас зохион байгуулсан дараах цахим сургалтад хамрагдсан. Үүнд:***

1. 2021.03.09-нд Мэдээллийн технологийн газраас зохион байгуулсан “Төрийн албаны шалгалтын хурууны хээгээр бүртгэл хийх” цахим сургалтад Мэдээлэл технологийн ажилтан П.Азжаргал;
2. 2021.03.17-нд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан цахим сургалтанд Улсын ахлах бүртгэгч Т.Оюунчимэг, улсын бүртгэгч Г.Батсайхан, С.Эрдэнэхишиг;
3. 2021.03.31-нд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан “Эрхийн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх, хүчингүй болгох, хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавих, цуцлах бүртгэлд анхаарах асуудлууд” цахим сургалтанд Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Ж.Болортуяа, Хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр, Улсын ахлах бүртгэгч Т.Оюунчимэг;

4. 2021.04.08-нд Бүртгэлийн Хяналтын газраас зохион байгуулсан цахим сургалтад Хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр, Улсын ахлах бүртгэгч Т.Оюунчимэг, улсын бүртгэгч Ж.Болортуяа;
5. 2021.04.19-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газраас зохион байгуулсан цахим сургалтад Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал;
6. 2021.05.07-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газраас зохион байгуулсан цахим сургалтад Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал;
7. 2021.05.10-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газраас зохион байгуулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжийн талаарх эрх зүйн сургалтанд Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал, Улсын ахлах бүртгэгч Б.Баттуяа, Хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр;
8. 2021.06.07-нд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан цахим сургалтад Улсын ахлах бүртгэгч Т.Оюунчимэг, улсын бүртгэгч Г.Батсайхан, С.Эрдэнэхишиг, Х.Хүрэлцэцэг;
9. 2021.06.17-нд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан цахим сургалтанд Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Ж.Болортуяа;
10. 2021.06.18-нд “Төрийн албаны тухай болон архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт” арга зүйн сургалтанд Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал, бичиг хэргийн ажилтан Г.Тэмүүлэн, Мэдээллийн технологийн инженер П.Азжаргал нар тус тус хамрагдсан.

Нийт 10 арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан 10 сургалтанд давхардсан тоогоор 23 албан хаагч хамрагдсан.



**Хэлтсээс болон орон нутгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулсан. Үүнд:**

1. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтанд хэлтсийн дарга, иргэний улсын бүртгэгч нар хамрагдаж мэргэшсэн.
2. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Байгууллагын хэвлэл мэдээллийн ажилтан”-ны танхимын сургалтад Мэдээллийн технологийн ажилтан
3. Аймгийн ЗДТГ-н Хууль зүйн хэлтсээс зохион байгуулсан “Сошеал медиа” танхимын сургалтад мэдээллийн технологийн ажилтан, нэг улсын бүртгэгч
4. Аймгийн онцгой байдлын газраас зохион байгуулсан “Газар хөдлөлтийн гамшиг” сэдэвт сургалтанд хэлтсийн төвийн албан хаагчид
5. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Хүүхдэд ээлтэй орчин” сургалтад нийт албан хаагчид
6. Иргэний бичиг баримт барьцаалах зөрчилд хяналт тавих сэдэвт сургалтанд 14 сумын улсын бүртгэгч нар
7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд ажиллах 58 итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн сургалтыг цахимаар



8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд ажиллах 58 итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн болон технологийн сургалтыг танхимаар



**Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит 2021 оны ээлжит сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнуудын эрх зүй, мэдээлэл, технологийн сургалт**

9. “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ” цахим сургалтанд хэлтсийн 18 албан хаагчийг хамруулж, бүгд амжилттай суралцаж 100 хувь гэрчилгээ авсан.



Нийт 7 арга хэмжээний хүрээнд 9 сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 185 албан хаагчийг хамруулсан. Үүнээс тайлант оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 5 сургалтыг амжилттай зохион байгуулсан байна.

## Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу хуульд заасан үүргээ хэрэгжүүлэн, ил тод байлгах, улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн нээлттэй, ил тод, шуурхай байдлыг хангах зорилтын хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг цаг тухайд нь хүргэж, сурталчилсан. Энэ хүрээнд:

- Аймгийн хэмжээнд шийдвэрлэгдэж буй зөрчлийг сумдаар нь болон төрлөөр нь ангилан сар, улирлаар судалгаа гаргаж, “Зөрчлөөс урьдчилан сэргийлье” самбарын мэдээллийг тогтмол шинэчилсэн.

- Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгө, архивын чиглэлээр 2021 оны 1-5 сарын тоон мэдээгээр инфографик мэдээлэл бэлтгэн, Дорноговь аймаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн нүүр номын хуудас, [www.dornogovi.burtgel.gov.mn](http://www.dornogovi.burtgel.gov.mn) цахим сайт, байгууллагын мэдээллийн самбарт байрлуулсан. Аймгийн засаг даргад бүртгэлийн үйлчилгээний сар бүрийн тоон мэдээг боршур байдлаар хэвлэн гаргаж хүргүүлсэн.

05-дугаар сар			04- дүгээр сар		
ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАСАГ			ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ		
ҮЙЛЧИЛГЭЭ	05-Р САРЫН БАЙДЛААР	ӨССӨН ДҮН	БҮРТГЭЛИЙН ТӨРӨЛ	4-Р САРД	НИЙТ
ТӨРӨЛТ	118	622	ХУВЬЦААТ КОМПАНИ	0	2
ҮРЧЛЭЛТ	7	12	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦИАГАТАЙ КОМПАНИ	5	1235
ОВОГ, НЭР ӨӨРЧЛӨЛТ	4	30	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА	1	203
ЭЦЭГ ТОГТООЛТ	7	35	ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР	0	2
ГЭРЛЭЛТ	26	153	ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР	0	7
ГЭРЛЭЛТ ЦУЦЛАЛТ	8	29	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ГАЗАР, УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР	0	192
НАС БАРАЛТ	25	137	НӨХӨРЛӨЛ	1	92
ГАДААД ПАСПОРТ ШИНЭ	40	153	ХОРШОО	0	64
ХАВСРАЛТ	178	813	ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	0	6
ИРСЭН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН	0	1643	САН	0	7
ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ	393	1835	ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГА	0	76
ЛАВЛАГАА	483	1854	ШАШНЫ БАЙГУУЛЛАГА	0	14
ДАХИН ГЭРЧИЛГЭЭ	44	160	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГА	0	2
Иргэний бүртгэлийн тасаг нь 2021 оны 05-р сард нийт 1333 иргэнд үйлчилгээ үзүүлж, Улсын төсөвт 10'056'900 төгрөг, Орон нутгийн төсөвт 1'496'900 төгрөг төвлөрдүүлсэн байна.			ТАТАН БУУТДАЖ УЛСЫН БҮРТГЭЛЭЭС ХАСАГДСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД - 0 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ - 20		
Улсын засаг бүртгэгч: ББАТТУРА			Улсын бүртгэгч: Ж. БОЛОРТУЯА		



# 05 дугаар сар



# 4-дүгээр сар



## ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ТАСАГ

ГАЗРААС БУСАДУЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ	ҮЙЛЧИЛГЭЭ	ГАЗАР
50	АНХНЫ БҮРТГЭЛ	109
115	ГЭРЭЭ ХЭЛЦЛИЙН БҮРТГЭЛ	31
20	БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ	12
563	БАРЬЦААНЫ ГЭРЭЭ ӨӨРЧЛӨЛТ	124
115	ЛАВЛАГАА	31

Дээрх үйлчилгээг үзүүлснээр Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь:

2021 оны 05-р сард нийт 1170 мэдүүлэг хүлээн авч зохих үйлчилгээг үзүүлж, үйлчилгээний хураамж 22'184'434 төгрөг, тэмдэглэлийн хураамж 1'252'427 төгрөг, Үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны татварт 56'940'180 төгрөг төвлөрүүллээ.

Улсын ажлаж бүртгэгч: Т.ОЮУНЧИМЭГ

## АРХИВ

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН АРХИВТ ХАЛГАЛАГДАЖ БАЙГАА ХУВИЙН ХЭРЭГ

ҮЛХӨДЛӨХ	14206
ГАЗАР	8007
НИЙТ	22213

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН АРХИВТ ХАЛГАЛАГДАЖ БАЙГАА ХУВИЙН ХЭРЭГ

ИРГЭНИЙ ХУВИЙН ХЭРЭГ	49938
ХҮҮХЭД ХААТР-11	25103
НАС БАРАЛТ	14992
НИЙТ	90033

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН АРХИВТ ХАЛГАЛАГДАЖ БАЙГАА ХУВИЙН ХЭРЭГ


НИЙТ ХУВИЙН ХЭРГИЙН ТОО	1902
-------------------------	------

Архивч Э.Эрдэнэмандал



## Хяналт, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, архивын 1-5 сарын тоон мэдээ

- Хэлтсээс зохион байгуулсан болон хэрэгжүүлж байгаа цаг үеийн онцлог ажлын мэдээлэл, сар бүрийн тоон мэдээг цахим сайт, нүүр номын хуудсанд тогтмол байрлуулсан.



### **Байгууллагын цахим сайтад цаг үеийн мэдээг байршуулав**

Цахим сайт болон нүүр номд нийт 51 мэдээллийг 130 удаагийн давтамжтайгаар, 30585 хүнд хүрсэн.

- Хэлтсийн үйлчилгээний танхимын гадна байрлах мэдээллийн самбарт холбогдох мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж, байрлуулсан.



- Мөн 7 хоног бүрийн цаг үеийн ажлын мэдээллийг АЗДТГ-ын Хууль эрх зүйн

хэлтэс, Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлж хэвшсэн нь орон нутгийн удирдлагад мэдээ мэдээллийг цаг алдалгүй хэлтсийн үйл ажиллагааны талаарх ойлголтыг таниулах, дэмжиж хамтран ажиллаж байна.

- Улсын бүртгэлийн нээлттэй утсаар хүлээж авсан дуудлага 647, гадагш залгасан дуудлага 112, санамж, анхааруулга, мэдэгдэл биечлэн тарааж өгсөн 160, мессэжээр 1018, нийт 1937 иргэн, байгууллагад хүргэсэн.

### **Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

Хэлтсийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжүүлсэн. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, албан хаагчдыг авлигаас ангид байх тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор авлигыг мэдээлэх, авлигаас урьдчилан сэргийлэх тухай албан хаагчдад танилцуулсан.

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу хэлтсийн төрийн захиргааны нийт албан хаагчид ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргаж, хэлтсийн дарга баталгаажуулсан.

Шинээр томилогдсон 2 албан хаагч томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ийг гаргаж мэдүүлсэн.

Тайлант хугацаанд албан хаагчидтай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар иргэн, байгууллагаас санал, гомдол ирээгүй.

### **Хүний нөөцийн ажлын хүрээнд:**

Тайлант хугацаанд сул орон тооны зарыг <http://dornogovi.burtgel.gov.mn> сайтад байрлуулж, иргэдээс ажилд орох хүсэлт, анкетыг хүлээн авсан. Ирүүлсэн анкетуудаас эхний шатны сонгон шалгаруулалтыг хийж шаардлага хангасан 4 иргэний материалыг УБЕГ-т хүргүүлсэн. Шинээр томилогдсон 2 албан хаагчийн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч УБЕГ-ын Захиргаа, хүний нөөцийн хэлтэст хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Ажлын цаг ашиглалт, сахилга, дэг журам, цар тахлын эсрэг дэглэмийг чанд мөрдөж ажиллахыг онлайн сургалтаар нийт албан хаагчдад үүрэг болгосон.

### **Мэдээллийн технологи, програм хангамж, тоног төхөөрөмжийн ажлын хүрээнд:**

Мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаж байна. Үүнд:

Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021.01.14-ны өдрийн А/02 тоот тушаалаар “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах,

хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ыг бүх албан хаагчдад хүргүүлсэн. Уг журмын дагуу хэлтсийн нийт 30 албан хаагчийн 34 компьютерийн үйлдлийн системийн нууц үг болон програмд нэвтрэх нууц үгийг сольж баталгаат гарын үсэг зуруулсан.

Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ сумдыг юнител группын 4G, Хөвсгөл, Хатанбулаг сумдыг шилэн кабелиар улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд бүрэн холбосон бөгөөд 14 сумын сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, доголдолгүй ажиллаж байна. Тухай бүрд хэлтэс болон сумдын дотоод сүлжээний гэмтэл саатал гарах тохиолдолд засварлаж бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн ажиллагаанд оруулсан.

Серверийн аюулгүй байдалд байнгын хяналт, цоож, лац, дохиоллын системийг тогтмол шалгаж, цэвэрлэгээ үйлчилгээг байнга хийж байсан. Мөн серверийг асааж унтраах тохиолдолд ашиглалтын дэвтэр хөтлөлтийг байнгын тэмдэглэл хөтлөсөн.

Хэлтсийн 6 компьютерт баталгаатай kaspersky anti virus-н програм суулгасан.

Хэлтсийн 2 болон сумын 3 компьютерийг форматлаж шаардлагатай програмуудыг суулгаж ажиллагаанд бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд бэлэн болгож өгсөн. Хэлтсийн компьютер, 7 принтерийн алдааг тухай бүрд нь засаж таниулж ажилласан.

Ажилд албан хаагч томилогдох болон чөлөөлөгдөх үед програмд нэвтрэх болон хаах эрхийг төлөвлөн МТГ-т хүргүүлэн ажилласан.

Иргэний үнэмлэх хэвлэх ажлыг тодорхой, тогтмол болгох зорилгоор биеийн давхцахгүй өгөгдлийг хуулбарласан мэдээллийг нэгж дээр тухай бүрт УБЕГ-ын серверт хуулсан.

УБЕГ-ын МТГ-т 4 дүгээр сард хэлтсийн техник, тоног төхөөрөмжийн судалгааг гарган хүргүүлсэн.

Хэлтсийн хэмжээнд онлайн болон оффлайн програм дээр шинээр програм суулгах болон дахин шинэчлэх үйлчилгээ хийсэн.

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуультай холбоотой 132 тоног төхөөрмж дээр ажиллах програмын сургалтыг хийсэн.

**Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:**

2021 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг албан хаагчдын санлыг үндэслэн, боловсруулж, батлуулсан. 2020 оны баримтаар хадгаламжийн нэгж бүрдүүлэн, байгууллагын архивт хүлээн авсан.

Тайлант хугацаанд 484 албан бичиг явуулж, ирсэн 414 албан бичгийг хүлээн авч, заавар, стандартын дагуу бүртгэж, даргын цохолтоор холбогдох албан

хаагчдад шилжүүлэн, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг хянаж, хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Хугацаа хоцруулсан албан бичиг байхгүй.

Албан хэрэг хөтлөлтийн ABLE програмд УБЕГ-т явуулсан 143, ирүүлсэн 30 албан бичгийг бүртгэсэн.

УБЕГ-ын даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 16, хүний нөөцтэй холбоотой 7 тушаал, бусад шийдвэрийн баримт бичгийг бүртгэн, танилцуулах хуудсаар нийт албан хаагчдад танилцуулж, биелэлтэд хяналт тавин, хэрэгжилтийг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлсэн.

Хэлтсийн даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 6, хүний нөөцтэй холбоотой 1 тушаалыг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж, даргаар батлуулан, холбогдох албан хаагчдад танилцуулсан.

Тайлант хугацаандиргэн, хуулийн этгээдээс нийт 25 өргөдөл, санал, хүсэлт ирсэн бөгөөд 25 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь 100%- тай байна.

Иргэний, Эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа болон албан хаагчдын ёс зүй, харилцаатай холбоотой асуудлаар аливаа гомдол, санал ирээгүй.

Засгийн газрын 11-11 төвд гомдолд байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын талаар гомдол, санал ирээгүй болно.

### **Бусад ажлын хүрээнд:**

1.Тус хэлтэс нь 2020 оны ажлын үр дүнгээр аймгийн **“ШИЛДЭГ АГЕНТЛАГ”**-аар шалгарч өргөмжлөлөө эрхэм гишүүд болон аймгийн удирдлагуудаасаа гардан авлаа.





2. Аймгийн ЗДТГ-т уламжилан дэмжлэг авч 5 ханатай өргөө цагаан гэрийг Сайхандулаан сумын улсын бүртгэгч М.Наранцацралд гардуулан өгсөн.



3. Энэтхэг улсад КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор АЗДТГ-аас зохион байгуулсан хандивын аянд хэлтсийн хамт олон нэгдэж 300.000 төгрөгийг хандивласан. УИХ-ын гишүүд, аймгийн Засаг дарга нар Энэтхэг улсын Элчин сайдад хандивыг гардуулан өгсөн.



4. Мод тарих үндэсний өдрөөр аймгийн наадмын талбай болон сумдын нутаг дэвсгэрт 30 модны нүх ухсан.



**Наадмын талбайд 30 модны нүх ухав**

5. Аймгийн нэгдсэн эмнэлгээс Донор цус цуглуулах аянд донор 4 албан хаагч цусаа бэлэглэсэн.



**Улсын бүртгэгч Б.Баянбат “Нигүүсэл” донор медалиар шагнуулав**

6. Ковид-19 ийн вакцинд нийт 30 албан хаагчдаас 27 албан хаагч хамрагдаж, Ковидийн шинжилгээг байгууллагаараа 3 удаа өгсөн.




7. 2021 онд Идэр өлзийт уламжлалт эмчилгээ эрхэлдэг эмнэлгийн судас барьж оношилдог эмч Түмэнжаргалыг ажлын байранд урьж авчиран албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт 1 удаа хамруулсан.



8. Дорноговь аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийн хүрээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангуулах, гамшгийн эрсдлийг бууруулах дадлага сургалтанд хамрагдав.





9. “Хариуцлагатай-хэрэглэгч” аяны хүрээнд 05 дугаар сард “Хүүхэд эрхэм хэрэглэгч” уриалгад нэгдэн, хэлтсийн 10 албан хаагч өөрсдийн гэрт хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн эсэхийг судалгаагаар үнэлэн, аюулгүй орчныг бүрдүүлэхэд анхаарч, албан хаагчдынхаа хүүхдийн гэртээ аюулгүй амьдрах орчныг үнэлж, түүний бүрдүүлэх уриалгад аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрыг дуудсан.



### **“ХҮҮХЭД ЭРХЭМ ХЭРЭГЛЭГЧ 2021”-аянд нэгдэв**

10. Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн Төрөх тасгийн эмч, сувилагч нар, СТ-4 маягтыг олгохдоо гаргаж байгаа алдаа, асуумжийг хэрхэн зөв бөглөх, СТ-4 маягтын үнэн зөв байдал нь улсын бүртгэлийг алдаагүй зөв явуулахад чухал ач холбогдолтой байдаг талаар Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Б.Баттуяа сургалт мэдээлэл хийсэн.



11. Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Ариунаа ВЕСТ ТББ-аас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж тус аймагт үйл ажиллагаа явуулдаг хөтөлбөрт хамрагдаж буй Төрийн бус байгууллагуудад хуулийн этгээдийн улсын бүртгэл, хугацаатай бүртгэлүүдийн талаар мэдээлэл өгсөн.



12. Нийтийн эзэмшлийн хуваарьт талбайн хог хаягдлыг сар бүрийн 25-ны өдөр Соёмбо цогцолборын гадна талбай буюу нийт иргэдийн амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, түр саатах саравч, авто зогсоол орчмын ахуйн болон зарим хог хаягдлыг цэвэрлэн тогтсон хогын цэгт хаяж нийт үйлчлүүлэгчдийн ая тухтай цэвэр эрүүл аюулгүй орчин бий болгох зорилгоор нийт алба хаагч бүрэн бүрэлдэхүүнээр цэвэрлэн үүрэг гүйцэтгэлээ.



***“Соёмбо” цогцолборын эргэн тойронд***

12. Сайншанд суманд “ДАРХЛААГ ДЭМЖИХ ЦАХИМ АЛХАЛТЫН 7 ХОНОГ” аянд хэлтсийн албан хаагчид нэгдэж дасгал хөдөлгөөнд идэвхтэй оролцсон.



ТАЙЛАН ХЯНАСАН  
ДАРГА:

Ц.ТЭГШЖАРГАЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН  
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Ө.СОНИНБАЯР

